

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан.

Аудитын код: ХӨА-2025/024/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99038632 Цахим хаяг: Ariuntuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/301
танай _____-ны № _____-т

“МӨРӨН ХОТ ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ” ХХК -ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ГАНЗОРИГ
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө өөрийн орлогоор 59.0 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,195.3 сая төгрөгөөр, шилжүүлэн авсан 782.8 сая төгрөгөөр, нийт 2,037.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 11.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 11.7 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, цаашид давтан гаргахгүй байхаар 4 зөвлөмжийг өгч, 1,770.5 сая төгрөгийн 3 залруулгыг аудитын хугацаанд залруулж ажиллаа.

Бусад асуудлын хэсэг

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөр 2024 оны бизнес төлөвлөгөөгөө батлуулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6712 020710

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  АЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	46,268.07	6,011,280.57
1.1.2	Дансны авлага	22,074,083.00	22,758,483.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.00	504,499.36
1.1.4	Бусад авлага	5,965,009.56	2,670,360.00
1.1.6	Бараа материал	81,221,871.43	108,436,913.29
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	109,307,232.06	140,381,536.22
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,925,224,052.45	3,317,280,057.99
1.2.2	Биет бус хөрөнгө	880,262,808.27	904,273,133.42
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,805,486,860.72	4,221,553,191.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,914,794,092.78	4,361,934,727.63
2.1.1.1	Дансны өглөг	115,857,287.55	4,480,698.81
2.1.1.2	Цалингийн өглөг	754,061.36	56,891.39
2.1.1.3	Татварын өр	108,160,511.00	1,147,262.76
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	5,600.00	549,910.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	288,254,873.42	6,234,762.96
2.2	Өр төлбөрийн нийт дүн	288,254,873.42	6,234,762.96
2.3	Эздийн өмч	6,772,480,793.00	6,772,480,793.00
2.3.1	Төрийн өмч	6,772,480,793.00	6,772,480,793.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,492,515,793.17	2,492,515,793.17
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,685,022,149.20	5,416,000,037.52
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-10,323,479,516.01	-10,325,296,659.02
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,626,539,219.36	4,355,699,964.67
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,914,794,092.78	4,361,934,727.63

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,690,055,709.19	2,096,921,278.05
3	Нийт ашиг (алдагдал)	1,690,055,709.19	2,096,921,278.05
5	Хүүний орлого	0.00	187,759.95
8	Бусад орлого	520,000.00	80,120,315.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,357,406,406.59	2,177,840,766.77
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-8,339,369.47	-1,186,953.25
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-675,170,066.87	-1,798,367.02
19	Орлогын татварын зардал	0.00	18,775.99
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-675,170,066.87	-1,817,143.01
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-675,170,066.87	-1,817,143.01
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-675,170,066.87	-1,817,143.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	1,578,050,557.46	2,089,377,697.72
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,578,050,557.46	2,089,377,697.72
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,626,070,216.01	2,083,600,445.17
1.2.1	Ажиллагчдад төлсөн	732,374,644.33	716,101,162.71
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	153,462,465.60	268,322,513.07
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	119,369,918.45	145,887,404.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	89,520,223.35	31,098,719.74
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	432,982,327.00	487,511,950.05
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	28,621,851.18	169,689,725.32
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	4,755,825.00	2,476,160.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	64,982,961.10	262,512,810.28
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-48,019,658.55	5,777,252.55
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	187,759.95
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	187,759.95
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	187,759.95
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-48,019,658.55	5,965,012.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,065,926.62	46,268.07
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,268.07	6,011,280.57

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,772,480,793.	0.	0.	2,492,515,793.17	0.	5,445,523,894.02	-9,648,309,449.14	5,062,211,031.05
3	Залруулсан үлдэгдэл	6,772,480,793.	0.	0.	2,492,515,793.17	0.	5,445,523,894.02	-9,648,309,449.14	5,062,211,031.05
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	0.	0.	0.	-675,170,066.87	-675,170,066.87
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	0.	0.	0.	-1,760,501,744.82	0.	-1,760,501,744.82
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,772,480,793.	0.	0.	2,492,515,793.17	0.	3,685,022,149.2	-10,323,479,516.01	2,626,539,219.36
10	Нягтлан бодох бүртгэлийн	0.	0.	0.	0.	0.	0.	0.	0.

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК/ОНӨҮГ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

	Бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	Залруулсан үлдэгдэл	6,772,480,793.	0.	0.	2,492,515,793.17	0.	3,685,022,149.2	-10,323,479,516.01	2,626,539,219.36
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	0.	0.	0.	-1,817,143.01	-1,817,143.01
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	0.	0.	0.	1,730,977,888.32	0.	1,730,977,888.32
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,772,480,793.	0.	0.	2,492,515,793.17	0.	5,416,000,037.52	-10,325,296,659.02	4,355,699,964.67

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны зорилт	Гүйцэтгэл	Биелэлт/хувь
1	Хог зайлуулалт	тн	24,000	18,850	78.54%
2	Гэрэлтүүлэг	Асалтын хувь	90	95	105.56%
3	Гудамж талбайн цэвэрлэгээ (сар тутамд)	м2	32000	32,000	100.00%
4	Ногоон байгууламжийн арчилгаа, цэцэрлэгжүүлэлт	м2	217544	217,544.00	100.00%
5	Түрж булах	тн	28000	40,000	142.86%
6	Золбин нохой устгал	ш	1666	1,831	109.90%
7	Борлуулалтын орлого	төг	1,700,000,000	2,096,921,278.05	123.35%
8	Нийт зардал Үүнээс Хөрөнгийн элэгдэл	төг	2,000,000,000	2,177,840,766.77	108.89%
		төг	500,000,000	372,413,604.38	74.48%
9	Орон нутгийн өмчийн ногдол ашиг	төг		-	
10	Авлага (бууралт)	төг	22,074,083	22,758,783.00	103.10%
11	Нийт өглөг Үүнээс богино хугацаат өглөг	төг	288,254,873.42	6,234,862.96	2.16%
12	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	төг	(300,000,000)	(80,919,488.72)	26.97%
13	Нийт ажиллагсдын тоо	хүн	73	62	84.93%
14	Нийт цалингийн сан	хүн	1,280,472,590	844,315,295.73	65.94%
15	Нийт зардалд цалингийн сангийн эзлэх хувь		64.00%	40.2%	62.8%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 11.7 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, цаашид давтан гаргахгүй байхаар 4 зөвлөмжийг өгч, 1,770.5 сая төгрөгийн 3 залруулгыг аудитын хугацаанд залруулж ажиллаа.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт1: Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,

удирдах;” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8/ “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдээгдлийг тооцсон байх” гэж заасантай болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Илрүүлэлт2: Албан хаагчдын болон гүйцэтгэх захирлын үндсэн цалинг тушаал шийдвэргүйгээр, бизнес төлөвлөгөөнд тусган 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэн олгож эхэлсэн байна. Энэ нь компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл 76.1.9."компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;" Компанийн дүрмийн 9.11 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.11.12 Гүйцэтгэх захирлын цалинг тогтоох, шагнаж урамшуулал олгох ба тэтгэвэрт гарах, өөр ажилд шилжих, чөлөөлөгдөх тохиолдолд тухайн байгууллагад ажилласан жил, ажлын үр дүнг харгалзан тэтгэмж олгох, 10.10.9 Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, цалингийн санд багтаан компанийн үйл ажиллагааг удирдаж, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх, сахилгын арга хэмжээ авах, цалин урамшууллын хэмжээг тогтоох асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх гэж заасантай болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Илрүүлэлт3: Компанийн үйл ажиллагааг хувийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэдэг 11 албан хаагчид сар тутам олгох шатахууны нормативыг батлахдаа гүйцэтгэх захирлыг сар тутамд 100 литр шатахуунаар хангах тухай шийдвэрийг гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн "6.1.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай болон "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

5.3 Зөвлөмж Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Байгууллагын дотоод хяналт, дотоод орчинтой холбоотой асуудал

Илрүүлэлт1: Дотоод хяналтын зөвлөлийн гүйцэтгэсэн ажлын тайлангаас үзэхэд Дотоод хяналт төлөвлөсөн ажлын хүрээнд хяналтуудаа бүрэн хийгээгүй буюу 5 ажилд хяналт хэрэгжүүлсэн, төлөвлөгөөнд ороогүй ч гэнэтийн хяналтуудыг хийж тайланд тусгасан байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн 2.3. “Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.” гэж заасантай болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг төлөвлөсөн хэмжээнд гүйцэтгэж , үр дүнг тооцон ажиллах

Илрүүлэлт2: “Мөрөн тохижилт үйлчилгээний төв” ХХК нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй нягтлан бодох бүртгэлээ хөтөлж, санхүү бүртгэл, үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” Компанийн дүрмийн 9.11.4-т “Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлах” гэсэн заалт болон Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах.

2.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт1: Худалдан авалтын тайланг гаргаж ирүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгө худалдан авах тухай хуулийн 3.1.”Улс, орон нутгийн төсөв

болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3.1.”Захиалагч тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд боловсруулж, журмын 2.7, 2.8-д заасан төлөвлөгөө батлуулах дарааллын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тухайн төсвийн жил дууссан даруйд цахим системээр тайлагнана.” гэж заасантай болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой төлөвлөгөө, тайланг хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, тайлагнан, цахим системд байршуулан ажиллах.

Илрүүлэлт2: Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд Шилэн данс цахим системд тайланг хугацаанд 158 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.” гэсэн заалт болон “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулан ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.”Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	16,450.0	1	16,450.0	0	0	1	16,450.0				
Эздийн өмчийн дүн Байдлын тайлан болон ӨӨТайланд зүүртэй	1	1,754,080.2	0	0	1	1,754,080.2	1	1,754,080.2				

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК/ОНӨҮГ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

тайлагнаг дсан												
Дүн	2	1,770,530.2	1	16,450.0	1	1,754,080.2	2	1,770,530.2				

Хүснэгт №-6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	6,234.7			1	6,234.7		
Бодлогын баримт бичиг	1	-					1	-
Худалдан авалт	1	-					1	-
Цалин	1	-			1	-		
Дотоод хяналт	1	-					1	-
Дүн	6	6,234.7			2	6,234.7	3	

Хүснэгт №-7. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хууль	1	5,450.9			1	5,450.9		
Шилэн дансны тухай хууль	1	-					1	-
Дүн	2	5,450.9			1	5,450.9	1	-

